

ХААН БАНК ХК
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ2025 оны 04 дүгээр
сарын 24-ний өдөр

№ 01

Улаанбаатар хот

Жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай

ХААН Банк ХК, Монгол Улсын нээлттэй хувьцаат компани (регистрийн дугаар 2693321, улсын бүртгэлийн дугаар 9007001013) (цаашид “Банк” гэх)-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурал дараах тогтоолыг үүгээр батлав. Үүнд:

ҮНДЭСЛЭЛ: Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62.1 дүгээр зүйлийн 62.1.9 дэх заалтад компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах асуудлыг зөвхөн хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэхээр заасныг;

ҮНДЭСЛЭЛ: Монгол Улсын Банкны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.6 дахь заалтад Банкны хувьцаа эзэмшигчдийн хурал банкны жилийн үйл ажиллагааны талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн тайланг хэлэлцэж батлах асуудлыг хэлэлцэж шийдвэрлэхээр заасныг;

ҮНДЭСЛЭЛ: Монгол Улсын Банкны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.7 дахь заалтад Банкны хувьцаа эзэмшигчдийн хурал аудитын байгууллагаар баталгаажуулсан санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах асуудлыг хэлэлцэж шийдвэрлэхээр заасныг;

ҮНДЭСЛЭЛ: Банкны Дүрмийн 7 дугаар зүйлийн 7.2.9 дэх заалтад Хувьцаа эзэмшигчдийн хурал нь Банкны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах бүрэн эрхийг хэрэгжүүлэхээр заасныг;

ҮНДЭСЛЭЛ: Банкны 2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын шийдвэрийг тус тус үндэслэн **ИЙНХҮҮ:**

- ТОГТООХ НЬ:** “Прайсуотерхаускуперс Аудит” ХХК-иар баталгаажуулсан Банкны 2024 оны санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хүлээн авсныг үндэслэн үүгээр баталсугай.
- ТОГТООХ НЬ:** Банкны 2024 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хүлээн авсныг үндэслэн үүгээр баталсугай.
- ТОГТООХ НЬ:** Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар шийдвэрлэсэн асуудал болон бусад холбогдох баримт бичгүүдийг Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон холбогдох бусад дүрэм, журамд заасан хугацаанд зохих эрх бүхий байгууллагуудад хүргүүлэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /В.Янжинлхам/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА  Т.ДАРЬБУМ

2693321

ХААН БАНК ХК
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ2025 оны 04 дүгээр
сарын 24-ний өдөр

№ 02

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн зардлын төсвийг батлах тухай

ХААН Банк ХК, Монгол Улсын нээлттэй хувьцаат компани (регистрийн дугаар 2693321, улсын бүртгэлийн дугаар 9007001013) (цаашид “Банк” гэх)-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурал дараах тогтоолыг үүгээр батлав. Үүнд:

ҮНДЭСЛЭЛ: Монгол Улсын Банкны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.9 дэх заалтад Банкны хувьцаа эзэмшигчдийн хурал Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүний бүрэн эрхийг тогтоох, хариуцлага, цалин, урамшууллын хэмжээ, Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны ерөнхий журмыг тогтоох асуудлыг хэлэлцэж шийдвэрлэхээр заасныг;

ҮНДЭСЛЭЛ: Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62.1 дүгээр зүйлийн 62.1.13 дахь заалтад Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээ, Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны ерөнхий журмыг тогтоох бүрэн эрхийг хэрэгжүүлэхээр заасныг;

ҮНДЭСЛЭЛ: Банкны Дүрмийн 7 дугаар зүйлийн 7.2.13 дахь заалтад Хувьцаа эзэмшигчдийн хурал нь Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүний бүрэн эрхийг тогтоох, хариуцлага, цалин, урамшууллын хэмжээ, Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны ерөнхий журмыг тогтоох бүрэн эрхийг хэрэгжүүлэхээр заасныг;

ҮНДЭСЛЭЛ: Банкны 2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын шийдвэрийг тус тус үндэслэн **ИЙНХҮҮ:**

- ТОГТООХ НЬ:** Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны зардлын төсвийг энэхүү тогтоолын Хавсралт №01-ийн дагуу баталсугай.
- ТОГТООХ НЬ:** Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар шийдвэрлэсэн асуудал болон бусад холбогдох баримт бичгүүдийг Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон холбогдох бусад дүрэм, журамд заасан хугацаанд зохих эрх бүхий байгууллагуудад хүргүүлэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /В.Янжинлхам/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА  Т.ДАРЬБУМ

2693321

ХААН БАНК ХК
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ2025 оны 04 дүгээр
сарын 24-ний өдөр

№ 03

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн бүтэц, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт
оруулах шинэчилсэн төлөвлөгөөг батлах тухай

ХААН Банк ХК, Монгол Улсын нээлттэй хувьцаат компани (регистрийн дугаар 2693321, улсын бүртгэлийн дугаар 9007001013) (цаашид “Банк” гэх)-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурал дараах тогтоолыг үүгээр батлав. Үүнд:

ҮНДЭСЛЭЛ: Монгол Улсын Банкны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсэгт аливаа этгээд дангаар болон холбогдох этгээдийн хамт эзэмших банкны хувьцаа, хувьцаанд хамаарах үнэт цаасны хэмжээ тухайн банкны нийт гаргасан хувьцааны 20 хувиас хэтрэхгүй байхаар заасныг;

ҮНДЭСЛЭЛ: 2021 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр батлагдсан Монгол Улсын Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 5 дугаар зүйлд энэ хууль хүчин төгөлдөр болохоос өмнө байгуулагдсан банк Банкны тухай хуулийн 36.1-д заасан шаардлагыг 2026 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор хангасан байхаар заасныг;

ҮНДЭСЛЭЛ: Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 5 тоот тогтоолын дагуу “ХААН Банк ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн бүтэц, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт оруулах шинэчилсэн төлөвлөгөө”-г баталж, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлэн батлуулахаар санал нэгтгэйгээр шийдсэн болохыг;

ҮНДЭСЛЭЛ: Банкны 2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын шийдвэрийг тус тус үндэслэн **ИЙНХҮҮ**:

- ТОГТООХ НЬ:** “ХААН Банк ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн бүтэц, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт оруулах шинэчилсэн төлөвлөгөө”-г энхүү тогтоолын Хавсралт №01-ийн дагуу баталсугай.
- ТОГТООХ НЬ:** Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар шийдвэрлэсэн асуудал болон бусад холбогдох баримт бичгүүдийг Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон холбогдох бусад дүрэм, журамд заасан хугацаанд зохих эрх бүхий байгууллагуудад хүргүүлэхийг ТҮЗ-ийн нарийн бичгийн дарга /В.Янжинлхам/-д үүрэг болгосугай.

